



ХЭНТИЙ АЙМГИЙН
МӨРӨН СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2026 оны 02 сарын 28 өдөр

Дугаар А/17

Мөрөн сум

Авто замын шинэчлэлийн ажил багц1-1
буталсан чулуун үйлдвэрийн газрын
түр зөвшөөрөл олгох тухай

Монгол Улсын “Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль”-ийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх заалт, Газрын тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.3 дэх заалт, Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.2.4 дэх хэсэг, Автозамын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.11 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Хэнтий аймгийн Мөрөн сумын нутаг дэвсгэрт хамаарагдах улсын чанартай А0501 дугаар бүхий Улааныаатар-Өндөрхаан чиглэлийн 68 км авто замын их засварын ажлыг хийж гүйцэтгэх “Чайна Роуд энд Бридж Корпорейшн” ХХК-д уг замын ажлыг дуусах хүртэл хугацаанд 3-р (Бүрээт) багийн нутаг дэвсгэр дэх тодорхой солбицол бүхий 5.4 га газрыг буталсан чулуун үйлдвэр байгуулах зориулалтаар түр ашиглах зөвшөөрөл олгосугай.

2.Буталсан чулуун үйлдвэр байгуулах газрыг зориулалтын дагуу, байгаль орчинд сөрөг нөлөөгүй, зохистой ашиглаж, авто замын ажлыг дуусахад нөхөн сэргээлт хийн хүлээлгэж өгөхийг “Чайна Роуд энд Бридж Корпорейшн” ХХК-д үүрэг болгосугай.

3.Буталсан чулуун үйлдвэр байгуулах газрын байршлын зураг, координатыг хавсралтаар баталсугай.

ДАРГА




ХАТАНБААТАР

Буталсан чулуун үйлдвэр байгуулах
газрын байршлын тойм зураг



Сумын Засаг даргын 2026 оны 01р
сарын 28-ны өдрийн 1/17 дугаар
захирамжийн хавсралт



Үйлдвэр байгуулах
газрын эргэлтийн цэг

д/д	X	У
1	47°23'09"	110°20'36"
2	47°23'05"	110°20'46"
3	47°22'59"	110°20'41"
4	47°23'01"	110°20'31"
Нийт талбайн хэмжээ		5.4 га